

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201.. оны ... дугаар сарын ... өдөр

Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалтыг нэмсүгэй.

1/6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9, 10 дахь заалт:

“6.1.9.хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд тэдгээрийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр шүүх болон бусад холбогдох эрх бүхий байгууллагад төлөөлөх, нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах;

6.1.10. Гадаад улсын эрх бүхий зохицуулагч байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, зөвлөлдөх, харилцан туслалцаа үзүүлэх;”

2/6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“6.3.Хороо энэ хуулийн 6.1, 6.2-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна үйл ажиллагааныхаа чиглэл тус бүрээр хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

3/17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“17.3.Хорооны дарга, гишүүн, албан хаагч хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, түүнд олгох цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмжээс гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана:

17.3.1.албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг, хэрэв хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг Хороо хариуцах;

17.3.2.албан хаагчийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг тухайн Хорооны төсвөөс төлөх;

17.3.3.албан хаагчийн хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд гарах зайлшгүй зардлыг Хорооны төсвөөс нөхөн олгох.”

4/20 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

“20.2.Хорооны дарга нь Хорооны төсвийн төслийг хянуулахаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд оруулна. Төсвийн байнгын хороогоор хянагдаж зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын төсөвт нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлнэ.

20.3.Төсөв нь Хорооны үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд уг төсөвт Хороо болон түүний орон нутаг дахь салбар, төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлаас гадна шинжилгээ судалгаа хийлгэх, гэрээт ажилтан, мэргэжлийн байгууллага, шинжээч ажиллуулах зардал, ажилтнуудын мэргэшил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагаа явуулах баталгааг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийг тусгана.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1 дэх хэсгийн “төрийн байгууллага” гэсний өмнө “хараат бус, бие даасан” гэж, 5.1 дэх хэсгийн “бие даасан” гэсний өмнө “хараат бус,” гэж, 6.1.3 дахь заалтын “хяналт тавих” гэсний дараа “санхүүгийн үйлчилгээ эрхлэх эрх бүхий этгээд, үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах” гэж, 6.1.5 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “төвлөрүүлэх” гэж, 17 дугаар зүйлийн “үйл ажиллагаа” гэсний өмнө “албан хаагчийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“2.1.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

2/3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“3.2. Банкны тухай хуульд Монголбанкны хяналт, зохицуулалтад хамаарахаар зааснаас бусад банкны санхүүгийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.”

3/6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 8 дахь заалт:

“6.1.4.зохицуулалтын хүрээний этгээдийн үйл ажиллагааг шалгах;

Тайлбар: зохицуулалтын хүрээний этгээд гэж тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд, түүнтэй нэгдмэл

сонирхолтой этгээд болон хуулиар Хорооны зохицуулалт, хяналтад хамаарахаар заасан бусад этгээдийг ойлгоно.

Нэгдмэл сонирхолтой этгээд гэж тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдтэй ашгийн төлөө болон ашгийн бус үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийг ойлгоно.

6.1.8.өөрийн зохицуулалтад хамаарах салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх,”

4/13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“13.2.Энэ хуулийн 13.1-д заасан үндэслэлээр Хорооны даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлүүлэх тухай саналыг түүнийг томилоход нэр дэвшүүлсэн этгээд, гишүүнийг ажлаас нь чөлөөлүүлэх тухай саналыг Хорооны дарга, эсхүл түүнийг нэр дэвшүүлсэн этгээд Улсын Их Хуралд оруулна.”

5/14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“14.2.Улсын Их Хурал энэ хуулийн 14.1.1, 14.1.4-д заасан тохиолдолд Хорооны даргыг түүнийг томилуулахаар нэр дэвшүүлсэн этгээдийн саналыг, Хорооны гишүүнийг түүнийг томилуулахаар нэр дэвшүүлсэн этгээдийн саналыг, эсхүл Хорооны даргын саналыг, 14.1.2, 14.1.3-т заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийг тус тус үндэслэн огцруулна.”

6/17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“17.2.Хорооны дарга, орон тооны гишүүн болон ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоо нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарын цалин хөлсний жишгийг баримжаалсан, өрсөлдөхүйц байх бөгөөд тэдгээрийн албан тушаалын цалингийн хэмжээг Хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.”

7/22 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“22.5.Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон үйл ажиллагааныхаа чиглэл тус бүрээр бусад хуульд зааснаар зохицуулна.”

8/24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“24.5.Хорооны хянан шалгагч энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан хяналт шалгалтыг эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.”

9/25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“25.1.8. зохицуулалтын хүрээний этгээд хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эсхүл хасах талаарх саналаа Хороонд оруулах;”

4 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээдээс” гэж, 6.1.6 дахь заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээд” гэж, 12.1 дэх хэсгийн “5” гэснийг “6” гэж, 17 дугаар зүйлийн “гишүүний” гэснийг “гишүүн” гэж, 20.1.2 дахь заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээдүүдээс” гэж, 23.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “Зохицуулалтын хүрээний” гэж, 24 дүгээр зүйлийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн” гэснийг “Зохицуулалтын хүрээний этгээдийн” гэж, 24.1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээд” гэж, 24.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “Зохицуулалтын хүрээний этгээд” гэж, 25.1.1 дэх заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн” гэснийг “шалгалтад хамрагдаж буй этгээдийн” гэж, 25.1.6 дахь заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээдийн” гэж, 25.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигчид” гэснийг “шалгалтад хамрагдаж буй этгээдэд” гэж, 26.1.1 дэх заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн” гэснийг “шалгалтад хамрагдаж буй этгээдийн” гэж, 26.1.2 дахь заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчээс” гэснийг “шалгалтад хамрагдаж буй этгээдээс” гэж, 26.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигчид” гэснийг “шалгалтад хамрагдаж буй этгээдэд” гэж, 26.3 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “шалгалтад хамрагдаж буй этгээд” гэж, 27.1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигчээс” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээдээс” гэж, 27.2, 27.3 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээд”, 33.1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээдүүдийн” гэж, 33.1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “зохицуулалтын хүрээний этгээд” гэж, 33.2 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “Зохицуулалтын хүрээний этгээд” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25.2 дахь хэсгийн “урьдчилан” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

